

**ОРХОН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА**

2024 оны 04 сарын 25

Дугаар 13-07/08

Баян-Өндөр сум

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний
даатгалын санд урьдчилан сэргийлэх
хяналт шалгалт хийсэн тухай

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 5.1, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн бүрдэл, зарцуулалтыг шалгаж, түүнтэй холбогдсон дүрэм, журам стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийн, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хугацаа

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч А.Уранчимэг нь тус газрын Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрүүдийн хооронд шалгалаа.

Гурав. Хяналт шалгалтад хамрагдсан асуудал

ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэмжийн баримт банк тус бүрээр 2021 оны 5 хавтас, 2022 оны 5 хавтас, 2023 оны 6 хавтас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн 390 хувийн хэрэг, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 35 хувийн хэрэг, 2021-2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 2 хавтас, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан файлаар (эх баримт аудитын газарт), 2021 оны аудитлагдсан тайлан, 2022-2023 аудитлагдсан тайлан файлаар зэрэг баримт материалууд шалгалтад хамрагдсан.

3.1 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын төрлийг хүснэгт №-01, сангийн зарцуулалтын төрлийг хүснэгт №-02, нэгтгэлийг хүснэгт №-03-аар нэгтгэн гаргалаа. Ажил олгогч болон даатгуулагчийн төлсөн

ҮОМШӨ-ний даатгал жил бүр нэмэгдсэн ч гүйцэтгэлийн хувь төлөвлөгөөндөө хүрсэн. Сангийн зарцуулалтын хувьд тахир дутуу болон тэжээгчийн алдсаны тэтгэвэр авагчдын тоо жил тутам буурсан хэдий ч тэтгэврийн хэмжээ өссөн нь засгийн газрын нэмэгдэлтэй холбоотойгоор сүүлийн жилд 600 гаруй сая төгрөгөөр нэмэгджээ.

3.2 Сүүлийн гурван жилд санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт (Хүснэгт 1)-ээс харахад:

Хүснэгт 1

Он	Зөвлөмж (зөрчлийн тоогоор)	Албан шаардлага		Акт		Нийт	
		Зөрчлийн тоо	Мөнгөн дүн (мян.төг)	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн (мян.төг)	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн (мян.төг)
2021	2	3	7734.6	1	1344.4	6	9079.0
2022	-	3	752.0	1	850.0	4	1602.0
2023	2	1	13621.2	2	1201.9	5	14823.1
дүн	4	7	22107.8	4	3396.3	15	25504.1

Дээрх зөрчлөөс 2021, 2022 оны албан шаардлага, актын биелэлтийг хугацаанд нь 100 хувь гүйцэтгэсэн, 2023 оны албан шаардлага, актын биелэлтийг энэ оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс өмнө гаргаж өгөхөөр ажиллаж байна.

3.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах сургалтын байгууллагыг сонгон шалгаруулалтаар сонгодог ба 2021 онд Facebook хуудас, вэб сайтад нийтэд байршуулж, гурван байгууллага хүсэлт ирүүлснээс “Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг” шалгаран, 8 сая (найман сая) төгрөгийн санхүүжилт авч, сургалтаа амжилттай зохион байгуулсан байна.

2022 онд “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, “Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг” хоёр байгууллага саналаа ирүүлснээс үнэлгээ хийх аргачлалын дагуу нэг бүрчлэн үнэлгээ өгч, 100 хувийн саналаар “Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг” дахин шалгарчээ.

Харин 2023 онд Төгс баян хүрээ ХХК, Эндээ хөгжил төрийн бус байгууллага, “Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг” нийт гурван байгууллага хүсэлт ирүүлснээс 83.2 оноогоор Эндээ хөгжил ТББайгууллага сонгогдон санхүүжилт авч гүйцэтгэлийг 100 хувь хийсэн байна.

Тус аймагт хөдөлмөрийн байцаагчид бүртгэгдсэн тоогоор үйлдвэрлэлийн осол 2021 онд 17, 2022 онд 16, 2023 онд 20, нийт 53 тохиолдол байна. Үүнээс ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэмж авсан даатгуулагчийн тоо 2021 онд 10, 2022 онд 14, 2023 онд 18, нийт 42 даатгуулагч (Хүснэгт 4) байгаа нь иргэдийн нийгмийн даатгалын талаарх хуулийн мэдлэг, мэдээлэл өмнө нь хомс байсан нь харагдаж байна. 2021 онд үйлдвэрлэл осолд өртсөн ч тэтгэмж тогтоолгож аваагүй 7 даатгуулагч байхад 2022 онд 2, 2023 онд 2 даатгуулагч болж буурсан нь нийгмийн даатгалын талаар иргэд, даатгуулагчдад хуулийг сурталчлан таниулах арга хэмжээ сайн хийгдэж байна.

3.4 Орхон аймгийн ЭММЗ-ийн програмын жагсаалтад байгаа, анх Орхон аймагт тэтгэврээ тогтоолгоод шилжиж явахдаа ЭММЗ-ийн програмд хуучин хаягаараа байгаа, хаяг өөрчлөгдөөгүй дараах тэтгэвэр авагчид байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

№	Овог нэр	Регистр	нөхцөл	шалтгаан
1	П.САРАНЦОГТ	PX73021911	ҮО	Булган аймагт тэтгэвэр авагч
2	А.ГАНЧИМЭГ	ЧЛ75071008	ҮО	БГД-т тэтгэвэр авагч
3	Л.ЭРДЭНЭЧИМЭГ	ФА49091261	МШӨ	БГД-т тэтгэвэр авагч
4	Л.БАТСАЙХАН	ФМ58060111	МШӨ	БГД-т тэтгэвэр авагч
5	Ц.БАТХУЯГ	3374042431	МШӨ	СБД-т тэтгэвэр авагч
6	Ц.НЯМДОРЖ	ФА55062277	МШӨ	СХД-т тэтгэвэр авагч
7	Б.ТӨМӨРХҮҮ	ФМ63100709	МШӨ	СХД-т тэтгэвэр авагч
8	Д.САРАНГЭРЭЛ	ФД73120206	ҮО	ХУД-т тэтгэвэр авагч
9	Ц.БАТЖАРГАЛ	ФБ67112561	МШӨ	ХУД-т тэтгэвэр авагч
10	Х.ТӨМӨРБАТ	ФБ62012305	МШӨ	ХУД-т тэтгэвэр авагч
11	Б.БАРНЯМБУУ	ФА52062076	МШӨ	ХУД-т тэтгэвэр авагч

ЭММЗ-ийн програмын жагсаалтад байхгүй, тус аймгийн НДГ-ын ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагч (Хүснэгт 3)-ийн актан дээрх хаяг хуучин хаягаараа бүртгэлтэй байна.

Хүснэгт 3

№	Овог нэр	Регистр	нөхцөл	шалтгаан
1	Т.СҮХБААТАР	ТГ63021910	МШӨ	актан дээр СХД-2 хороо хаягтай
2	Б.ОД	ФА61090178	МШӨ	актан дээр БЗД-26 хороо хаягтай
3	Д.САНЖХҮҮ	ФБ50102013	МШӨ	актан дээр Булган орхон хаягтай
4	Ч.ТҮВШИНБАЯР	РД68021012	ҮО	сүүлийн 3 акт ахуйн осолоор сунгагдсанг эмчид хянуулж, үйлдвэрлэлийн осол болгон засуулсан
5	M.ALEXANDER	ЮД48110737	ҮО	2009 оноос хойш хугацаагүй, 2023.09 сараас олголтгүй, судалж байгаа

Чадраабалын Түвшинбаяр (РД68021012)-ын 363699 дугаар хувийн хэргийг шалгахад 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Монгема ХХК-д үйлдвэрлэлийн осолд өртсөн, 2020 оны 08 дугаар сараас хойшхи сунгалт хийсэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон сүүлийн гурван акт ахуйн ослоор сунгагдсаныг магадлагч эмчид шалгуулан, үйлдвэрлэлийн осол болгон засуулж, хувийн хэрэгт хавсаргасан.

Макрашины Александр (ЮД48110737)-ын 134505 дугаар хувийн хэрэг 2013 оноос хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт хугацаагүйгээр сунгагдсан. Тэтгэврийн програмд хасагдах хугацааг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөр хийснээр түүнээс хойш тэтгэврийн олголтгүй. Улсын бүртгэлийн хэлтсээс лавлахад Гадаадын иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн хилээр гараагүй байна гэсэн мэдээлэл өгсөнөөс өөр мэдээлэлгүй, судалж байна.

3.5 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас нийт 390 тэтгэвэр авагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байгаагаас 48 тэтгэвэр авагч үйлдвэрлэлийн ослоор, 342 тэтгэвэр авагч мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тэтгэвэр авч байна. Шинээр 2021 онд 6, 2022 онд 11, 2023 онд 9, нийт 26 тэтгэвэр тогтоолгожээ.

Харин тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн хувьд аймгийн хэмжээнд одоогийн байдлаар 35 тэтгэвэр авагч уг сангаас тэтгэвэр авч байгаагаас 16 тэтгэвэр нь үйлдвэрлэлийн ослоор, 17 тэтгэвэр нь мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр нас барж, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон, 2 тэтгэвэр авагч шилжиж явсан, зогсоогдсон хөдөлгөөнтэй байна. Шинээр 2021 онд 1, 2022 онд 1, 2023 онд 3, нийт 5 тэтгэвэр тогтоолгосон.

Тус сангаас 2023 онд 4332,8 сая төгрөгийн тэтгэврийг харилцах банкуудаар олгосон.

3.6 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид 2021 онд 10 даатгуулагчдад 30.7 сая төгрөг, 2022 онд 14 даатгуулагчдад 42.4 сая төгрөг, 2023 онд 18 даатгуулагчдад 76.6 сая төгрөг, нийт 149.6 сая төгрөгийг олгосон байна. (Хүснэгт 4)

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан ажил олгогч, даатгуулагчийн тоогоор харуулбал:

Хүснэгт 4

Он	Ажил олгогч	Салбар	Даатгуул агчийн тоо	Нийт даат.тоо	Мөнгөн дүн (сая.төг)
2021	1. 1-р сургууль	боловсрол	1	10	30.7
	2. НИК ХХК Орхон салбар	худалдаа	1		
	3. Тэмүүжин оргил ХХК	худалдаа	1		
	4. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	үйлдвэр	3		
	5. Эрдэнэт ус, ДТС ОНӨХК	үйлчилгээ	1		
	6. Эрдэнэт хивс ХХК	үйлдвэр	2		
	7. Эрдэнэтлайт ХХК	худалдаа	1		
2022	1. Баян-Өндөр сум ЗДТГ	үйлчилгээ	1	14	42.4
	2. Бүсийн оношлогоо э.төв	үйлчилгээ	1		
	3. Мэргэжлийн сургалт ү.төв	боловсрол	2		
	4. Тод өнгө ХХК	үйлчилгээ	1		
	5. Хот тохижуулах газар	үйлчилгээ	1		
	6. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	үйлдвэр	6		
	7. Эрдэнэт хивс ХХК	үйлдвэр	2		
2023	1. 4-р сургууль	боловсрол	1	18	76.6
	2. 7-р цэцэрлэг	боловсрол	2		
	3. Ачит ихт ХХК	үйлдвэр	1		
	4. ДЦС ТӨХК	үйлчилгээ	1		
	5. Найм дахь гариг	худалдаа	1		
	6. ОРАМЕТАЛЛ ХХК	худалдаа	1		
	7. Хаан банк	үйлчилгээ	1		
	8. Хот тохижуулах газар	үйлчилгээ	1		
	9. Эрдмийт ХХК	худалдаа	1		
	10. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	үйлдвэр	6		
	11. Эрдэнэт мах маркет ХХК	худалдаа	1		
	12. Эрдэнэт хивс ХХК	үйлдвэр	1		
Нийт дүн			42	42	149.6

3.7 Рашаан, сувиллын зардалд 2021 онд 96 даатгуулагчдад 25.5 сая төгрөг, 2022 онд 293 даатгуулагчдад 182.3 сая төгрөг, 2023 онд 437 даатгуулагчдад 284.7 сая төгрөгийг зарцуулсан.

3.8 ЭММЗ-ийн цахим програмын жагсаалтад байгаа даатгуулагч Халтарын Пүрэвдорж (ИЦ70041430) нь 2010 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хөдөлмөр чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актыг ахуйн ослоор гаргасан, тухайн үед иргэн нь үйлдвэрлэлийн ослын актаа авчирч өгөөгүй байна. 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар орохдоо уг үйлдвэрлэлийн ослын актаа авчирч өгөн, актаа сунгуулсан байна. Хэвийн нөхцлөөр тэтгэврийг тогтоосонг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин болгоход тэтгэврийн мөнгөн дүнд өөрчлөлт орохгүй байна.

3.9 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 390 тэтгэвэр авагч тэтгэвэр авагч байгаагаас 29 тэтгэвэр авагч одоогийн байдлаар ажил хөдөлмөр эрхэлж байна. Үүний 8 тэтгэвэр авагч үйлдвэрлэлийн ослоор, 21 тэтгэвэр авагч мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тэтгэвэр тогтоолгосон.

Дөрөв. Шалгуулагч этгээд, хяналт шалгалтын объектын талаарх мэдээлэл

Тус Нийгмийн даатгалын газар нь Удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх төрийн захиргааны ажилтан 28, төрийн үйлчилгээний ажилтан 5, гэрээт ажилтан 4, нийт батлагдсан 38 орон тоотойгоор ажиллаж байна. Нийт 4 тасагтайгаас Санхүү бүртгэлийн тасаг 5, Хамралт орлого шимтгэлийн тасаг 5, Хяналт шалгалтын тасаг 6, Үйлчилгээний тасаг 21, Жаргалант сумын байцаагч 1 орон тоотой.

Сангийн хөрөнгийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг НДЕГ-ын даргын 2023.01.23-ны өдрийн Б/14 тоот тушаалаар Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах, хоёрдугаар гарын үсэг НДХ-ийн даргын 2023.01.25-ны өдрийн Б/12 тоот тушаалаар Санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч Ү.Мягмарсүрэн нар гарын үсэг зурж байна.

Тав. Өмнөх хийсэн хяналт шалгалтын түүх

ҮОМШӨ-ний даатгалын санд 2017 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2017 оны 01/98 дугаартай удирдамжаар НХХУБайцаагч Н.Баясгалан 2014, 2015, 2016 оны санхүүгийн болон төлбөр, зардалтай холбогдох баримтууд, 452 тэтгэврийн хувийн хэрэгт үндэслэн шалгалт оржээ.

Дээрх шалгалтаар 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн №14/22 дугаар улсын байцаагчийн акт тавигдаж, ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3 дахь заалтууд, НХХСайд, ЭМСайдын 2003 оны 74/116 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт “ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний төлбөр олгох журам”-ын 1.2, 1.3 дугаар заалтуудыг тус тус зөрчсөнөөс 3 иргэнтэй холбоотой 2.672.500 төгрөгийн төлбөр зөрчил тавигдаж, 100 хувь барагдсан байна.

Зургаа. Хяналт шалгалтаар тогтоогдсон бодит нөхцөл байдал

ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуугийн тэтгэвэр авч буй иргэдийн судалгааг хүснэгт №-06–аар гаргахад нийт 390 тэтгэвэр авагчаас үйлдвэрлэлийн ослоор 48, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөр 342 тэтгэвэр авагч байна. Энэ нь аймгийн томоохон үйлдвэр болох “Эрдэнэт үйлдвэр” ТӨХК, “Эрдэнэт хивс” ХХК-ний ажлын байрны хүнд, хортой нөхцөлөөс шалтгаалж тэтгэвэр авагчдын тоо бусад аймаг, дүүргүүдээс өндөр үзүүлэлттэй байна. Сүүлийн гурван жилд шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид 2021 онд 6, 2022 онд 11, 2023 онд 9, нийт 26 тэтгэвэр шинээр тогтоолгожээ.

Дээрх 390 тэтгэвэр авагчдын хөдөлмөр эрхлэлтийг шалгаж үзэхэд:

- 321 иргэн ажил хөдөлмөр эрхлээгүй,
- 40 иргэн урьд нь ажил хөдөлмөр эрхэлж байсан,
- 29 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байна.

Мөн үйлдвэрлэлийн ослоор 48 иргэн тэтгэвэр тогтоолгосноос үүний 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдсаны акт хугацаагүйгээр сунгагдсан.

Долоо. Хяналт шалгалтын явцад авсан арга хэмжээ, өгсөн зөвлөгөө:

Хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэр авагчдын хувийн хэргийн бүрдэл, олголтыг шалгах явцад дараах зөрчлүүд илэрсэнг засаж залруулсан. Үүнд:

- Дашзэвэгийн Банзрагч (АО83082017)-гийн 2231220610001 дугаар хувийн хэрэгт үйлдвэрлэлийн ослын актыг хавсаргаагүй байсныг шалгалтаар илрүүлэн, тэтгэврийг хянасан байцаагчид хариуцуулан өгч, үйлдвэрлэлийн ослын актыг хувийн хэрэгт хавсарган, хувийн хэрэг хариуцсан архивын ажилтанд хүлээлгэн өгсөн.
- ЭММЗ-ийн програмын жагсаалтанд нэр нь байгаа Эрдэнэбатын Бумдарь (ФА71111960)-ийн 2230619610002 дугаар хувийн хэргийг татаж үзэхэд үйлдвэрлэлийн ослын актаа тэтгэвэр тогтооход өгөөгүйгээс хэвийн нөхцлөөр тогтоогдсон байна. Тухайн иргэнтэй холбогдож үйлдвэрлэлийн ослын актыг хавсарган нөхцлийг өөрчилсөн. Тэтгэврийн мөнгөн дүн өөрчлөлт ороогүй.
- ЭММЗ-ийн програмын жагсаалтанд нэр нь байгаа Халтарын Пүрэвдорж (ИЦ70041430)-ийн 238815 дугаар хувийн хэргийг татаж үзэхэд хэвийнээр тогтоолгосон, анхны акт ахуйн ослоор гарсан, сүүлийн хоёр сунгалтын акт (2022.10.12-2023.10.12, 2023.10.12-2024.10.12) үйлдвэрлэлийн ослоор сунгагдсан байсанг магадлагч эмчид хянуулж, шалгуулахад 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар орохдоо иргэн өөрөө үйлдвэрлэлийн ослын актаа авчирч дахин хянуулсан, ЭММЗ-ийн програмд тайлбартайгаар оруулж, үйлдвэрлэлийн осол болгон актыг сунгасан байна. Тухайн иргэнтэй холбогдож үйлдвэрлэлийн ослын актыг хавсарган нөхцлийг өөрчлөхөөр болсон. Тэтгэврийн мөнгөн дүнд өөрчлөлт ороогүй. Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын дагуу тухайн даатгуулагчийн 2.051.328 (хоёр сая тавин нэгэн мянга гурван зуун хорин найман) төгрөгийн шимтгэлийн төлбөрийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас Тэтгэврийн даатгалын сан руу шилжүүлэхээр тооцоо гарсан.

Найм. Дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал

Тус аймгийн хэмжээнд 2021-2023 онуудад үйлдвэрлэлийн осол буурахгүй байгаа нь улсын хэмжээний томоохон үйлдвэр болох Эрдэнэт үйлдвэр ТӨҮГазартай холбоотой үйлдвэрлэлийн осол 2021 онд 3, 2022 онд 6, 2023 онд 6, нийт 15 осол буюу 35%-ийг эзэлж байна.

Тоо мэдээний Хүснэгт 4-ийг салбараар нь авч үзвэл: (даатгуулагчийн тоогоор)

№	Салбар	2021 он	2022 он	2023 он	Дүн
1	Боловсрол	1	2	3	6
2	Худалдаа	3	-	4	7
3	Үйлчилгээ	1	4	3	8
4	Үйлдвэр	5	8	8	21
Нийт дүн		10	14	18	42


Цаашид 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн авах талаарх сургалтыг аж ахуйн нэгж, байгууллагуудад хийж, гадагшаа чиглэсэн сургалтад анхаарах нь зүйтэй.

Мөн тэтгэвэр тогтоолтын байцаагчид анхан шатан дээр нь үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоохдоо тухай иргэний үйлдвэрлэлийн осолд орсон актыг эх хувиар нь бүрдүүлж, тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргаж хэвших хэрэгтэй байна.

ХЯНАСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГЙИГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ  Д.НАРМАНДАХ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ  А.УРАНЧИМЭГ